

МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДРӨӨР ...

СПОРТООР “АМЬСГАЛАВ”



цэргийн хэргийн мэдлэг, ур чадвараа дайчлан өрсөлдсөн бөгөөд Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн ахлах дэслэгч Ц.Лхагвасүрэн, Онцгой байдлын газрын дэслэгч Г.Сүрэнжав, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дэслэгч Ш.Дамдинсүрэн ахлагчтай тасгууд эхний байруудыг тус тус эзэллээ.

Үүнээс гадна Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн нэрэмжит буудлага /автомат, гар буу, мэргэн буудагчийн винтов/-ын зэвсгийн бооцоот тэмцээнд 11 байгууллагын 40 гаруй алба хаагч оролцсоноос байгууллагын дүнгээр дэд хурандаа Н.Гурбадам захирагчтай Зэвсэгт хүчний 256 дугаар анги, хурандаа Б.Мөнх-Эрдэнэ даргатай аймгийн Цагдаагийн газар, хурандаа Ж.Уламбаяр даргатай Тагнуулын хэлтсийн багууд эхний байруудыг эзэлсэн юм.

Тэрчлэн “Эх орон танаа” цэргийн дуу дуулаачдын тэмцээнийг аймгийн ЗДТГ, Соёл урлагийн газар, Хайрхан дулаан сумын Соёлын төв

Зэвсэгт хүчний 256 дугаар анги

“Монгол цэргийн өдөр”, орчин цагийн Зэвсэгт хүчний 101 жилийн ойг тохиолдуулан Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд спортын 4 төрлөөр тэмцээн зохион байгууллаа. Тэмцээнд 6 байгууллагын 200 гаруй баг тамирчин оролцож хурд, хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс “Сагсан бөмбөг”-ийн төрлөөр I байрт Зэвсэгт хүчний 256 дугаар анги, II байрт 113 дугаар салбар, III байрт Онцгой байдлын газрын баг тамирчид шалгарлаа. Түүнчлэн “Гар бөмбөг”-ийн төрлөөр дэд хурандаа Н.Гурбадам ахлагчтай Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн удирдлагын баг тамирчид тэргүүн байрт, хурандаа Б.Мөнх-Эрдэнэ ахлагчтай Цагдаагийн газрын баг тамирчид дэд байрт, шүүгч Б.Нэргүй ахлагчтай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны



баг тамирчид гутгаар байрт шалгарсан юм.

Мөн аймгийн Засаг даргын нэрэмжит “Марш тактик, тусгай бэлтгэлийн аварга тасаг” шалгаруулах тэмцээнд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын 6 багийн 50 гаруй тамирчин авхаалж самбаа, тэсвэр хатуужил,

хамтран аймгийн Хөгжимт драмын театрт зохион байгууллаа. Уг тэмцээнд 20 гаруй уран бүтээлчид өрсөлдсөнөөс Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн Цэргийн цагдаагийн тасгийн дарга хошууч З.Гансэлэм гуравдугаар байрт шалгарлаа.

Дэслэгч Т.АЛТАНТУУЛ

АЛБА ХААГЧДЫНХАА АР ГЭРИЙН ТӨЛӨӨЛӨЛТЭЙ ...

Зэвсэгт хүчний 353 дугаар анги

“Монгол цэргийн өдөр”, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 101 жилийн ойг тохиолдуулан цэргийн алба хаагчдын ар гэрийг дэмжих ажлын хүрээнд бие бүрэлдэхүүний ар гэрийн төлөөллийг урьж ангийн үйл ажиллагаатай танилцуулан “Алдрын тасалгаа”, дэслэгч генерал Ч.Пүрэвдоржийн нэрэмжит танхимаар зочлууллаа. Энэ үеэр “Золбоо төгс дайчид” караоке дууны уралдаан, нийтийн цэнгээнт бүжиг зэргийг зохион байгуулсан юм.

Зэвсэгт хүчний 101 жилийн ойн баяраар тус ангийн 60 цэргийн алба хаагч салбарын медаль, 3 цэргийн алба хаагч Налайх дүүргийн Засаг даргын



жуух бичиг, нэг цэргийн алба хаагч хошууч цол, ахлагчийн албанд ажиллаж буй 4 алба хаагч Агаарын цэргийн

командлагчийн тушаалаар цалинтай чөлөөгөөр шагнагдав.

Ахмад Б.НАНДИНЦЭЦЭГ

БАЙЛДАГЧДЫН ДУНД СУРГАЛТ, УУЛЗАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 032 дугаар анги

“Монгол цэргийн өдөр”, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ойн баярын өдрөөр ЦДБЭЧ-ын сургалт, соёл хүмүүжил, маркетингийн албаны дарга дэд хурандаа Р.Өнөржаргалыг урин хугацаат цэргийн алба хаагчдад “Хувь хүний маркетинг” сэдвээр сургалт, санал бодлоо солилцсон уулзалтыг зохион байгууллаа. Энэ үеэр УХТР-ын байлдагч М.Мөнх-Оргил, Б.Азжаргал, Г.Батбаатар, Б.Золбаяр нарт гарын бэлэг гардуулан, дайчдад баярын



мэндчилгээ дэвшүүлэн, хугацаат цэргийн алба үлгэр жишээ хаах хүсэл эрмэлзэл, хүндэт харуулын албаараа бахархах сэтгэлийг өрнүүлсэн халуун алга ташилтаар дүүрэн ач холбогдол бүхий арга хэмжээ боллоо. Төгсгөлд нь хугацаат цэргийн алба хаагчидтай дурсгалын зураг татуулсан юм.

Мөн Хан-Уул дүүргийн нэгдүгээр хорооны Засаг дарга Б.Сэлэнгэ ажлын хэсгийн хамт хугацаат цэргийн албанд тагтагдан ирсэн түрүүч Б.Содбаярыг эргэн ирж, гарын бэлэг гардуулан, нийт хугацаат цэргийн алба хаагчдад баярын мэндчилгээ дэвшүүллээ.

ЗЭВСЭГТ ХҮЧИН БОЛОН АНГИА СУРТАЛЧЛАВ

Зэвсэгт хүчний 167 дугаар анги

Энэ сарын 14-16-ны өдрүүдэд “Монгол цэргийн өдөр” Зэвсэгт хүчний 101 жилийн ой, Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг угтан иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Баяндалай, Ханхонгор сумдад Зэвсэгт хүчин, ангийн үйл ажиллагааг сурталчлах өдөрлөгийг зохион байгууллаа. Тус өдөрлөгийн хүрээнд урлаг соёлын арга хэмжээ болон уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулж иргэдэд ангийн танилцуулга, Монгол Улсын Зэвсэгт хүчин, энхийг дэмжих ажиллагааны онцлог, үүргийн талаар товч яриа таниулга хийж мэдээлэл хүргэв.

Мөн өдөрлөгийг үеэр Баяндалай сумаас гаралтай цэргийн алба хаагчид сумынхаа сургуулийн нэгэн танхимыг тохижуулан, эдэлж хэрэглэж



байсан хувцас хэрэглэлийг дурсгал болгон өгч “Орон нутаг судлах танхим”-тай танилцаж номын сангийн баяжилтад ном хандивлав. Түүнчлэн сагсан бөмбөг, гар бөмбөг, буудлага, нормативын тэмцээн, Ханхонгор сумын ахлах ангийн сурагчдын дунд “Эх орон” сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг тус тус зохион байгуулж явууллаа.

Зэвсэгт хүчний 234 дүгээр анги

Энэ сарын 14-17-ны өдрүүдэд Орхон, Булган аймгийн цэргийн хүрээний төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулагдсан спортын бага наадамд “Усчин дайчид” амжилттай оролцож, сагсан бөмбөгийн эрэгтэй төрөл болон олс таталтын төрлөөр хүрэл медаль, модон морин дээгүүр харайх төрөл, волейболын эрэгтэй төрлөөр мөнгөн медалийн эзэд боллоо.

* Алба, салбар сурталчлах аяны хүрээнд “Цэргийн гал тогоо”-ны хамт олон амьдралын зөв



дадал зуршлыг бий болгох зорилгоор “Эрүүл бие-Эрүүл хооллолт” уриан дор бие бүрэлдэхүүнд халуун цай, чацаргана, 5 төрлийн сонголттой хоол, 10 төрлийн салат зуушаар үйлчлэв.

* 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Булган аймгийн Хангал сумын ЕБС-ийн сурагчид, ард иргэдийн дунд иргэн-цэргийн харилцааг бэхжүүлж, цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэх, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилгоор видео шторк үзүүлэн, мэдээ мэдээлэл хийж, сурагчдын дунд хөгжөөнт тэмцээн зохион байгууллаа.



* Нийт ЦАХ-чдын дунд “ПМ, АК буугаар буудлагын бооцоот тэмцээн”, “Гранат шидэлт”-ийн тэмцээнийг зохион байгууллаа. Гар бууны төрлөөр I байрт дэслэгч Ч.Сугаррагчаа, II байрт захирагч хурандаа Г.Эрдэнэбаяр, III байрт дэслэгч Б.Мөнхбат шалгарав. АК бууны төрлөөр I байрт дэд ахлагч Ч.Баярмагнай, II байрт дэслэгч Б.Мөнхбат, III байрт ахлагч Б.Энхболд, “Гранат шидэлт”-ийн тэмцээний I байрт ахлагч Л.Манлайбаяр, II байрт дэслэгч Б.Мөнхбат, III байрт дэд ахлагч Э.Өсөхбаяр нар шалгарлаа.

* Хялганат тосгоны ард иргэдэд цэргийн алба хаагчдын бэлтгэсэн гардан тулаан, жагсаалын үзүүлэх тоглолтыг үзүүлж, Хялганат тосгоны Соёлын төвд оройн цэнгүүнийг зохион байгууллаа. Хялганат тосгоны хөгжимчин Г.Лхагвацэнгэл морин хуурын аялгуураар, ахлах ахлагч М.Бат-Эрдэнэ, Д.Батхуяг нар “Баярын жагсаал”, байлдагч Э.Бат-Эрдэнэ “Байлдагчийн дуу”-гаар тус тус мэндчилгээ дэвшүүлэв. Энэ үеэр үзэгчдийн дунд ангийн захирагчийн нэрэмжит азын “10+1” сугалааг явуулж, супер азтанаар Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн хөвүүр гүүрний ротын ахлах гүүр тавигч-жолооч ахлагч Б.Түмэнбаяр тодорлоо.

Дэслэгч Ч.ОЮУНЧИМЭГ